



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 5/01

Мандалговь

Т.Эрдэнэзаяаг мэргэжилтнээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.3 дэх хэсэг, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, “Журам батлах тухай” 2018 оны 382 дугаар тогтоолын 1, 6 дугаар хавсралтууд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дэх хэсэг, “Бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай” аймгийн Засаг даргын 2024 оны А/04 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Луус сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Түмэнжаргалын Эрдэнэзаяагийн 2024 оны 08 дүгээр сарын 26-ний өдрийн өргөдөл, Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 02-ний өдрийн Б/15 дугаар тушаалын дагуу Тус газрын Усны нөөц ашиглалт, хамгаалалт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнээр 2024 оны 09 дүгээр сарын 02-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Т.Эрдэнэзаяагийн албан тушаалын үндсэн цалинг ТЗ-9 буюу 1,210,000 (Нэг сая хоёр зуун арван мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 6 хувиар, орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар, хоолны үнийн хөнгөлөлтийг өдрийн 8000 (найман мянга) төгрөгөөр тус тус тогтоож, томилогдсон өдрөөс эхлэн хууль, тогтоомжийн дагуу тооцож олгохыг ерөнхий нягтлан бодогч (А.Нэргүй)-д зөвшөөрсүгэй.

3. Усны нөөц ашиглалт, хамгаалалт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн Түмэнжаргалын Эрдэнэзаяаг байгууллагын дүрэм, журам, бичиг баримтуудтай танилцуулан, Төрийн албан хаагчийн хувийн хэргийг холбогдох журмын дагуу бүрдүүлэн

Tushaal B.docx

482401003

хүний нөөцийн системд албан хаагчийн мэдээллийг бүрэн оруулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батхүү)-д даалгасугай.

4.Холбогдох хууль, тогтоомж, газрын дүрэм, журмуудыг чанд сахин, гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан идэвх зүтгэл гарган хариуцсан ажлаа чанартай гүйцэтгэж ажиллахыг (Т.Эрдэнэзаяад)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ГАНТУЛГА